



ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ХҮСЭЛТЭЙ ЭТГЭЭДЭД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.10.08 № 1053
танай _____-ны № _____-т

Шинжээч сонгон шалгаруулах зар
хүргүүлэх тухай

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь “Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж, дүгнэлт гаргах зорилгоор санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй /Үндэсний аудитын газраас гаргасан хураангуй жагсаалтад орсон/ аудитын хуулийн этгээдүүдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно. Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Ажлын даалгавар
- Саналын жишиг баримт бичиг
- Гэрээний ерөнхий, тусгай нөхцөл

Мэргэжлийн зөвлөх шинжээч нь “Ажлын даалгавар”-т тусгасан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд төрийн аудитын байгууллагын хянан удирдах ажилтнуудаар хянуулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

Оролцох хүсэлтэй шинжээч нь “Саналын жишиг баримт бичиг”-ийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын www.audit.mn хаягаас 50,000.0 төгрөгөөр /дансаар/ эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр худалдан авна.

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 17 цаг 30 минутаас өмнө доорх хаягаар авч болох бөгөөд саналаа 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 09:00 цагийн дотор ub@audit.gov.mn цахим хаягаар

цахим /нэгтгэсэн pdf файл/ хэлбэрээр ирүүлнэ үү. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахгүй болно.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитын хоёрдугаар хэлтсийн ахлах аудитор Ж.Бадамгарав. badamgaravj@audit.gov.mn, утас (976) 88076101

Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Соёлын төв өргөө, "Г" корпус, 5 давхар, Нийслэл дэх Төрийн аудитын газар

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ